

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 8/44

Чойр

Санхүүгийн хяналт, шалгалтын улсын ахлах
байцаагч, дотоод аудиторын албан тушаалын
тодорхойлолтыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай" 03 дугаар тогтоолоор баталсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-ын 5.1 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн "Зөвшөөрөл олгох тухай" 248 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Говьсүмбэр аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны Санхүүгийн хяналт, шалгалтын улсын ахлах байцаагч, дотоод аудиторын албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлөөс олгосон зөвшөөрлийн дагуу хавсралтаар баталсугай.

2. Дээрх албан тушаалын тодорхойлолтын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Л.Одонтуяа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Н.АЛТАНЦЭЦЭГ

4216030020

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- ☒ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- ☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Говьсүмбэр аймгийн Санхүүгийн
хяналт, аудитын Алба

Нэгжийн нэр:

Албан тушаалын нэр:

Санхүүгийн хяналт, шалгалтын улсын
ахлах байцаагч, дотоод аудитор

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-6

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Говьсүмбэр аймаг Сүмбэр сум 3 дугаар баг
Нутгийн удирдлагын ордон 309 тоот

Хөдөлмөрийн нөхцөл:

хэвийн

Онцгой нөхцөл:

хамаарахгүй

II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Санхүүгийн болон бусад хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- 1.Санхүүгийн болон бусад хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах.
- 2.Төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж чиглэлийг өгч, биелэлтийг хангуулах.
- 3.Монгол Улсын хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг, дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх– Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, гэрээг мөрдөж байгаа байдалд хяналт тавьж, дотоод аудитын бодлогыг хэрэгжүүлэх;	Дотоод аудитын бодлого хэрэгжихүйц хийгдсэн байна.	Г
	2.Дотоод аудит, бусад үйл ажиллагааг хийх, хэрэгжүүлэх;		Г
	3.Хяналт шалгалтын дүнд тулгуурлан эрх зүйн орчинг боловсронгуй болгох саналыг боловсруулах;		Г
	4.Хяналт шалгалтын дүнд тулгуурлан салбарын хэмжээнд хэрэгжүүлэх, шийдвэрлүүлэх арга хэмжээний саналыг боловсруулах;		Г
	5.Удирдлагыг мэргэжлийн зөвлөгөө, зөвлөмж, танилцуулга, мэдээлэл, судалгаагаар хангах.		Г
	1.Салбарын хүрээний ажил үүргийг чиглэл тус бүрээр хяналтад оруулан албан хаагчдыг үр дүнтэй төлөвлөлттэй ажиллуулах;		Г
	2.Байгууллагын болон салбарын сургалтуудыг зохион байгуулж явуулах;		Г



2 дугаар зорилтын хүрээнд	3.Иргэд, төсвийн, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагыг мэдээлэл, зөвлөмжөөр хангах;	Эрсдэлтэй объектын тоо буурч, хуулийн хэрэгжилт хангагдана.	Г
	4.Хяналт шалгалтын үйл ажиллагааг удирдамж, төлөвлөлт, арга зүй, хөтөлбөрийн хүрээнд хийж гүйцэтгэх;		Г
	5.Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус санхүүгийн, гүйцэтгэлийн, нийцлийн аудит хийж үр дүнг тооцох;		Г
	6.Хяналт шалгалтын явцад өөрийн чиг үүрэгт үл хамаарах зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд удирдлагад мэдээлж, холбогдох газарт мэдэгдэхээр уламжлах;		Г
	7.Хийсэн хяналт шалгалтын дүнг хэлэлцүүлэж гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах;		Г
	8.Дотоод аудитын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах;		Г
	9.Хяналт шалгалтын дүнг нэгтгэн цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмжийг боловсруулж хэлэлцүүлэх, шалгалтын дүнг холбогдох газарт хүргүүлэх;		Г
	10.Иргэд байгууллагын хүсэлт өргөдлийг шийдвэрлэх.		Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Монгол Улсын Үндсэн хууль бусад хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх;	Хууль тогтоомж, дүрэм журам, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангасан байна.	Г
	2.Бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэр, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах;		Г
	3.Архивын тухай хууль, албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, албан бичгийн стандартыг мөрдөж албан хэрэг хөтлөлтөнд үүссэн баримт бичгийн бүрдүүлэлт эмх цэгцийг хариуцан, хадгаламжийн нэгж бүрдүүлж архивт шилжүүлэх;	Албан хэрэг, архив хөтлөлт стандартын дагуу хөтлөгдөж сайжирсан байна.	Г



4.Удирдлагын хуульд нийцсэн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэж ажиллах, эргэн мэдээлэх;	Шуурхай хэрэгжүүлж эргэн мэдээлсэн байна.	Г
5.Төрийн албан хаагчийн үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн хэм хэмжээ, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар гарсан бодлого шийдвэр, хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөж ажиллах;	Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдөж ажилласан байна.	Г
6.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэн ажиллах;	Хөдөлмөрлөх нөхцөл хангагдсан байна.	Г
7.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, тайлагнах;	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, тогтоосон хугацаанд тайлагнасан байна.	Г
8.Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх, тайлагнах.		Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.
Мэргэжил	Санхүү, банк (041201-), Нягтлан бодох бүртгэл (041101), Эдийн засаг (031101), Эрх зүй (042101).
Мэргэшил	Төрийн албанд мэргэшүүлэх богино, дунд хугацааны багц сургалтанд хамрагдаж төгссөн байх; Дотоод аудит, хяналт шалгалт, төрийн удирдлагын чиглэлээр сургалтанд хамрагдаж мэргэжсэн байх. Мэргэшсэн нягтлан бодогч байх;
Туршлага	- Дэс түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил эсхүл төрийн албанд 2-оос доошгүй жил ажилласан байх; - Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх.
Дүн шинжилгээ хийх	- Судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх; - Нэгтгэж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах; - Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - Бусад.
	- Үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх; - Хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг



Ур чадвар	Асуудал шийдвэрлэх	боловсруулах; - Шинэчлэл өөрчлөлт хийхийг зорьдог байх; - Өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг байх; - Аливаа үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх; - Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээг сахих - Ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх; - Хууль, эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх; - Бүтээлч, санаачлагатай ажиллах; - Бусад.
	Багаар ажиллах	- Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтойгоо хуваалцаж, бие биеэ дэмждэг байх; - Багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх; - Багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах; - Үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - Хамт олонч сэтгэлгээтэй, зэрэг уур амьсгалыг дэмждэг байх; - Нээлттэй шударга байх; - Бусад.
	Бусад	- Өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх - Зарчимч, тууштай, ажил хэрэгч байх; - Шинэ санал, санаачлага, бүтээлч хандлагатай байх; - Хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх; - Албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх; - Компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах; - Төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулгын чадвартай байх; - Англи хэл эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх. - Албан ажлын чиг үүргийнхээ зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх; - Хариуцсан ажлаа төлөвлөх, зохион байгуулах;

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Байхгүй.

Бусад харилцах субъект:

- Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын холбогдох албан хаагч;
- Төсөл хөтөлбөрийн ажилтан;
- Төрийн бус байгууллагын холбогдох ажилтан;
- Иргэн хуулийн этгээд, төрийн бус байгууллагын холбогдох ажилтан.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ, ДОТООД
АУДИТОР

..... Л.ОДОНТУЯА
20... оны ... дугаар сарын ...-ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 19 11 04

Дугаар: 248

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН АЛБА

Шийдвэрийн огноо: 2019 11 11

Дугаар: 114

(тамга/тэмдэг)

ДАРГА...../Н.АЛТАНЦЭЦЭГ/

УСД0051 4614194
4245101662

2019 оны 11 дугаар сарын 11-ны өдөр





МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2019 оны 11 сарын 04 өдөр

Дугаар 148

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2019 оны 17 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 4.5 дахь заалт, “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2016 оны 9 дүгээр тогтоолын 4 дэх заалт, “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 4.1, 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн Говьсүмбэр аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг хянан хэлэлцээд **ТОГТООХ** нь:

1.Говьсүмбэр аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны Санхүүгийн хяналт, шалгалтын улсын ахлах байцаагч, дотоод аудиторын албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр хавсралтаар, Санхүүгийн хяналт, шалгалтын улсын байцаагч, дотоод аудиторын албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлахыг аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга /Н.Алтанцэцэг/-д зөвшөөрсүгэй.

2.Хянаж зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолт тус бүрийг албажуулах, баталж мөрдүүлэх, нэгдсэн санд бүртгэх үйл ажиллагааг мэргэшил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллахыг Ажлын алба /Б.Алтанзул/-нд даалгасугай.

3.Зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолтыг эрх бүхий албан тушаалтнаар батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Говьсүмбэр аймаг дахь салбар зөвлөл /Д.Содномд/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ

ТАЗ тогтоол 2019

19000358

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- ☒ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан
шинэчлэн боловсруулсан
- ☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Говьсүмбэр аймгийн Санхүүгийн хяналт,
аудитын Алба

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Санхүүгийн хяналт, шалгалтын улсын
ахлах байцаагч, дотоод аудитор

Дэс түшмэл, ТЗ-6

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдөр 8 цаг

Говьсүмбэр аймаг Сүмбэр сум 3 дугаар баг
Нутгийн удирдлагын ордон 309 тоот

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Санхүүгийн болон бусад хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын өмнө хариуцна.